

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/149/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4 Материаллаг байдал.....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа.....	20
4.2 Төлбөрийн акт	20
4.3 Албан шаардлага.....	20
4.4 Зөвлөмж.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББ	Нягтлан бодох бүртгэл



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуулмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/128
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант оны эцэст 41,633.4 мянган төгрөгийн бараа материалыг биечлэн тоолоогүй, тооллогын үр дүнг хэлэлцэж, баталгаажуулаагүй, 2,647.1 мянган төгрөгийн авлага, 6,693.9 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-т "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/", 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

19020398

D 2022/2022 он/ALBAN BICHIG

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,735,120.59	44,280,566.22
33	АВЛАГА	1,267,178.59	2,647,111.22
335	Бусад авлага	1,267,178.59	2,647,111.22
3351	Байгууллагаас авах авлага	337,178.59	1,717,111.22
3352	Хувь хүмүүсээс авах авлага	930,000.00	930,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	39,467,942.00	41,633,455.00
354	Хангамжийн материал	39,467,942.00	41,633,455.00
35410	Бичиг хэргийн материал	265,248.00	1,409,973.00
35420	Аж ахуйн материал	33,951,042.00	39,286,642.00
35460	Хүнсний материал	5,251,652.00	891,840.00
35470	Бусад хангамжийн материал		45,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,328,137,269.88	2,425,726,843.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,328,137,269.88	2,425,726,843.33
392	Биет хөрөнгө	1,316,659,269.88	2,414,248,843.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,199,787,207.74	2,301,287,207.74
39202	Хуримтлагдсан элэгдэл	69,646,290.12	108,279,580.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,412,501.00	55,496,804.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	43,467,344.36	39,294,113.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,237,217.00	125,865,041.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	22,372,274.52	38,870,709.68
39209	Зам, гүүрийн байгууламж	42,912.00	42,912.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	159,776,073.00	159,776,073.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	44,358,741.51	52,259,697.39
39217	Ном	10,248,009.65	10,484,905.81
393	Биет бус хөрөнгө	11,478,000.00	11,478,000.00
39301	Программ хангамж	536,500.00	536,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	536,500.00	536,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,478,000.00	11,478,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,368,872,390.47	2,470,007,409.55
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	6,693,887.12
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	6,693,887.12
413	Өглөг	-	6,693,887.12
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		425,000.00
4136	Бусад өглөг	-	6,268,887.12
41361	Байгууллагад төлөх өглөг		6,268,887.12
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,368,872,390.47	2,463,313,522.43
51	Засгийн газрын хувь оролцоо	1,368,872,390.47	2,463,313,522.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	675,096,458.81	675,096,458.81
51101	Өмч: - төрийн	675,096,458.81	675,096,458.81
512	Хуримтлагдсан үр дүн	693,775,931.66	1,788,217,063.62
51210	Өмнөх үеийн үр дүн	12,853,672.97	12,897,933.24
51220	Тайлант үеийн үр дүн		1,094,441,131.96
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	680,922,258.69	680,877,998.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,368,872,390.47	2,470,007,409.55

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	696,502,412.00	1,874,526,147.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	553,754,912.00	1,672,898,522.21
120	Нийтлэг татварын бус орлого	9,025,712.00	1,149,658,822.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,025,712.00	1,149,658,822.21
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,025,712.00	1,149,658,822.21
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	544,729,200.00	523,239,700.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	544,729,200.00	523,239,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	142,747,500.00	201,627,625.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,815,700.00	49,623,825.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,815,700.00	49,623,825.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	120,931,800.00	152,003,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	120,931,800.00	152,003,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	738,786,368.49	780,085,015.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	738,786,368.49	780,085,015.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	669,102,598.56	730,292,611.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	412,954,344.30	410,503,960.38
210101	Үндсэн цалин	281,667,943.30	345,605,745.47
210102	Нэмэгдэл	75,445,199.00	44,075,692.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,345,033.00	6,279,403.91
210104	Урамшуулал	40,496,169.00	14,543,119.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,656,259.07	56,262,661.91
210201	Тэтгэврийн даатгал	38,300,259.53	40,599,123.13
210202	Тэтгэмжийн даатгал	4,136,230.51	4,331,096.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,308,843.71	3,344,497.88
210204	Ажилгүйдлийн даатгал	809,957.68	726,940.39
210205	Эрүүл мэндийн даатгал	8,100,967.64	7,261,003.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,843,428.00	143,311,566.00
210301	Гэрэл, цахилгаан	2,109,960.00	5,358,366.00
210302	Түлш, халаалт	113,533,468.00	137,682,500.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	270,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,088,900.00	3,437,225.00
210401	Бичиг хэрэг	395,900.00	984,425.00
210402	Тээвэр, шатахуун	501,000.00	1,835,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,000.00	202,500.00
210404	Ном, хэвлэл	77,000.00	67,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	165,000.00	62,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	285,000.00

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	18,109,730.00	41,481,749.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	138,800.00	500,000.00
210502	Хоол, хүнс	16,603,430.00	38,784,449.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,367,500.00	2,197,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,365,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	1,365,000.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	240,000.00	-
210702	Дотоод албан томилолт	240,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,324,500.00	432,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,324,500.00	432,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,520,437.19	72,363,448.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,500.00	209,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,645,000.00	5,275,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,799,937.19	66,879,448.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,683,769.93	49,792,404.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,820,450.00	46,122,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,084,750.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,858,500.00	31,334,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,957,200.00	13,869,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,000.00	918,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,052,206.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,052,206.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,811,113.93	3,670,304.20
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,811,113.93	3,670,304.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(42,283,956.49)</u>	<u>1,094,441,131.96</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(42,283,956.49)</u>	<u>1,094,441,131.96</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,096,458.81	680,922,258.69	55,137,629.46	1,411,156,346.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	675,096,458.81	680,922,258.69	55,137,629.46	1,411,156,346.96
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-42,283,956.49	-42,283,956.49
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,096,458.81	680,922,258.69	12,853,672.97	1,368,872,390.47
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,096,458.81	680,922,258.69	12,853,672.97	1,368,872,390.47
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			44,260.27	44,260.27
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	675,096,458.81	680,922,258.69	12,897,933.24	1,368,916,650.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-44,260.27		-44,260.27
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			1,094,441,131.96	1,094,441,131.96
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,096,458.81	680,877,998.42	1,107,339,065.20	2,463,313,522.43

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	687,476,700.00	724,867,325.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	687,476,700.00	724,867,325.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	544,477,200.00	523,239,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	544,477,200.00	523,239,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,815,700.00	49,623,825.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,815,700.00	49,623,825.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	121,183,800.00	152,003,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	121,183,800.00	152,003,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	681,636,150.00	724,867,325.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	681,636,150.00	724,867,325.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	616,804,140.07	665,708,805.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	412,716,817.00	410,469,758.80
210101	Үндсэн цалин	281,430,416.00	266,069,390.87
210102	Нэмэгдэл	75,445,199.00	115,501,804.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,345,033.00	10,725,986.93
210104	Урамшуулал	40,496,169.00	18,172,577.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,656,259.07	55,845,400.00
210201	Тэтгэврийн даатгал	38,300,259.53	38,189,572.14
210202	Тэтгэмжийн даатгал	4,136,230.51	5,245,827.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,308,843.71	3,309,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	809,957.68	827,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,100,967.64	8,273,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,131,594.00	143,132,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,398,126.00	5,250,200.00
210302	Түлш, халаалт	113,533,468.00	137,682,500.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,270,100.00	9,144,525.00
210401	Бичиг хэрэг	396,000.00	717,225.00
210402	Тээвэр, шатахуун	574,000.00	750,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,000.00	252,500.00
210404	Ном, хэвлэл	77,000.00	335,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	165,000.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,408,100.00	6,929,800.00
2105	Нормативт зардал	23,817,470.00	27,986,322.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	138,800.00	500,000.00
210502	Хоол, хүнс	22,381,670.00	24,686,422.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,297,000.00	2,799,900.00

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	8,871,100.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	8,871,100.00
2107	Томилолт, зочны зардал	240,000.00	300,000.00
210702	Дотоод албан томилолт	240,000.00	300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,324,500.00	2,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,324,500.00	2,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,647,400.00	7,459,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,500.00	1,399,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,571,900.00	6,060,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,832,009.93	59,158,519.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,968,690.00	55,488,215.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,232,990.00	9,366,115.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,858,500.00	31,334,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,957,200.00	13,869,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,000.00	918,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,052,206.00	3,670,304.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,052,206.00	3,670,304.20
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,811,113.93	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,811,113.93	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,840,550.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,840,550.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,840,550.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	5,840,550.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,840,550.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,840,550.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	675,243,500.0	671,573,195.8	3,670,304.2	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	675,243,500.0	671,573,195.8	3,670,304.2	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	661,868,800.0	661,289,080.8	579,719.2	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,469,900.0	410,469,758.8	141.2	100.0
210101	Үндсэн цалин	281,827,400.0	266,069,390.9	15,758,009.1	94.4
210102	Нэмэгдэл	87,550,600.0	115,501,804.0	(27,951,204.0)	131.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,256,000.0	10,725,986.9	3,530,013.1	75.2
210104	Урамшуулал	26,835,900.0	18,172,577.0	8,663,323.0	67.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,845,400.0	55,845,400.0	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	39,298,700.0	38,189,572.1	1,109,127.9	97.2
210202	Тэтгэмжийн даатгал	4,136,700.0	5,245,827.9	(1,109,127.9)	126.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,309,400.0	3,309,400.0	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	827,300.0	827,300.0	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8,273,300.0	8,273,300.0	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,132,700.0	143,132,700.0	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	5,250,200.0	5,250,200.0	-	100.0
210302	Түлш, халаалт	137,682,500.0	137,682,500.0	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	200,000.0	200,000.0	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	9,495,000.0	9,024,800.0	470,200.0	95.0
210401	Бичиг хэрэг	350,000.0	597,500.0	(247,500.0)	170.7
210402	Тээвэр, шатахуун	750,000.0	750,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.0	252,500.0	247,500.0	50.5
210404	Ном, хэвлэл	335,000.0	335,000.0	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.0	160,000.0	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,400,000.0	6,929,800.0	470,200.0	93.6
2105	Нормативт зардал	28,094,700.0	27,986,322.0	108,378.0	99.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.0	500,000.0	-	100.0
210502	Хоол, хүнс	24,794,700.0	24,686,422.0	108,278.0	99.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,800,000.0	2,799,900.0	100.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,871,100.0	8,871,100.0	-	100.0
210604	Урсгал засвар	8,871,100.0	8,871,100.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	300,000.0	300,000.0	-	100.0

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	300,000.0	300,000.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,500,000.0	2,500,000.0	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.0	2,500,000.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,160,000.0	3,159,000.0	1,000.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.0	1,399,000.0	1,000.0	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,760,000.0	1,760,000.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,374,700.0	10,284,115.0	3,090,585.0	76.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,374,700.0	10,284,115.0	3,090,585.0	76.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,454,200.0	9,366,115.0	3,088,085.0	75.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,500.0	918,000.0	2,500.0	99.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	675,243,500.0	675,243,500.0	-	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	523,239,700.0	523,239,700.0	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	523,239,700.0	523,239,700.0	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	152,003,800.0	152,003,800.0	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	152,003,800.0	152,003,800.0	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	36.0	36.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	23.0	23.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	12.0	12.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49,623,825.00	49,623,825.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49,623,825.00	49,623,825.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,419,725.00	4,419,725.00
2104	Хангамж, бараа материалын зардал	119,725.00	119,725.00
210401	Бичиг хэрэг	119,725.00	119,725.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,300,000.00	4,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,300,000.00	4,300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,204,100.00	45,204,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,204,100.00	45,204,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,334,500.00	31,334,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,869,600.00	13,869,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	49,623,825.00	49,623,825.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,623,825.00	49,623,825.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,623,825.00	49,623,825.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэлийг аккурэл сууриар хөтлөхтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дах Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр цахимаар ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахыг зорилгоо болгон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулаагүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын тушаалаар томилогдсон дотоод хяналтын баг нь 2021 оны ажлаа төлөвлөн, дотоод хяналтыг хэрэгжүүлэн, улирал бүр тайлагнаж ажилласан.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын

алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 675,243.5 мянга төгрөгөөс 1,5 хувиар буюу 10,128.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,596.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 675,243.5 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 49,623.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 724,867.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 1,101,500.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 8,338.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 54,393.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 236.9 мянган төгрөгийн ном, нийт 1,164,469.0 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж,

тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 15,235.2 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 1,147,733.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 425.0 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 42,942.8 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 41,202.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 2,647.1 мянган төгрөгийн авлага, 6,693.9 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Энэ нь байгууллага, хувь хүнээс авах авлага, байгууллагад төлөх өглөг байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулаагүй байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 41,633.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 2,425,726.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	1,267.2	2,647.1	1,379.9
Урьдчилгаа	-		-
Бараа материал	39,467.9	41,633.5	2,165.6
Үндсэн хөрөнгө	1,328,137.3	2,425,726.8	1,097,589.5
Нийт хөрөнгө	1,368,872.4	2,470,007.4	1,101,135.0
Өр төлбөр	-	6,693.9	6,693.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,368,872.4	2,463,313.5	1,094,441.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,368,872.4	2,470,007.4	1,101,135.0

Бараа материалын дансны үлдэгдэл 41,633.5 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 2,165.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,425,726.8 мянган төгрөг болж 1,097,589.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлогоос шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,463,313.5 мянган төгрөг болж 1,094,441.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 675,243.5 мянган төгрөгөөр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 675,243.5 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвөөс 675,243.5 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 671,573.2 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 3,670.3 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 671,573.2 мянган төгрөг буюу 99.5 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 49,623.8 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний зардалд 4,419.7 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 45,204.1 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 1,101,500.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 8,338.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 54,393.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 236.9 мянган төгрөгийн ном, нийт 1,164,469.0 мянган төгрөгийн хөрөнгийн орлого нэмэгдсэн.

Тайлант хугацаанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглагдах боломжгүй 8,019.9 мянган төгрөгийн хөрөнгийг Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн шийдвэрийн дагуу акталсан.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны эцэст 41,633.4 мянган төгрөгийн бараа материалыг биечлэн тоолоогүй, тооллогын үр дүнг хэлэлцэж, баталгаажуулаагүй, 2,647.1 мянган төгрөгийн авлага, 6,693.9 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-т “Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/”, 72 дугаар зүйлийн 72.4.4-д “Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 131 мэдээлэл, 8 мэдээллийг хугацаа хоцроож, 7 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалтын дагуу файлаар болон цаасаар бүрэн бүрдүүлж өгөөгүй, санхүүгийн тайлангийн холбогдох журнал, дэлгэрэнгүй бүртгэлийг файлаар ирүүлээгүй, санхүүгийн тайлангаа баталгаажуулж, цаасаар ирүүлээгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,251.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, 7,329.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Ихмонгол Хөлөг Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гарч байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 санхүүгийн тайланд аудит хийх явцад аудитад шаардлагатай санхүүгийн тайлан, бусад холбогдох материалаа хуулийн хугацаа хоцроосноос цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл үүсэж, шалгагдагч байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар цалинтай холбоотой шийдвэрүүд болон үндсэн хөрөнгө, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг шалгаагүй тул дараагийн аудитаар цалинтай холбоотой ажил гүйлгээ, үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэлийг нарийвчилсан горим хэрэгжүүлэн шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 52,369.2 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 1,275.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 50,974.5 мянган төгрөгийн зөрчил арилгах 4 албан шаардлага хүргүүлж, 119.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулга хийгдээгүй.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 1,275.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд анхан шатны баримтгүй 1,275.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг бүртгэж тайлагнасан нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн анхан шатны баримтгүй зарцуулсан шатахууныг холбогдох ажилтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар 50,974.5 мянган төгрөгийн зөрчил арилгах 4 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Захирлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/23 дугаар "Эд хөрөнгийн тооллогын комисс томилох тухай" тушаалаар эд хөрөнгө тоолох ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, тооллогыг гүйцэтгэхдээ 41,633.5 мянган төгрөгийн бараа материалыг биечлэн тоолоогүй, тооллогын үр дүнг хэлэлцэж, баталгаажуулаагүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/", 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн хөрөнгийн тооллогыг бодитой гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Санхүүгийн тайланд тусгагдсан 2,647.1 мянган төгрөгийн авлага, 6,693.9 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, баталгаажсан үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Байгууллагын НББ-ийн үйл ажиллагаанд НББ-ийн бодлогын баримт бичиг ашигладаггүй, НББ-ийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн боловсруулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 131 мэдээлэл, 8 мэдээллийг хугацаа хоцроож, 7 мэдээллийг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 119.7 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг шууд зардалд бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын НББ-ийг аккруэл сууриар хөтлөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Дэлгэрхаан сумын Ерөнхий боловсролын сургууль	6	52,369.2	-	-	1	1,275.0	4	50,974.5	1	119.7

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn